



“ТАВАН ТОЛГОЙ ТҮЛШ” ХХК ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2021 оны 02 сарын 17 өдөр

Дугаар А/17

Улаанбаатар хот

Журам шинэчлэн батлах тухай

Төрийн болон орон нутгийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.10 дахь заалт, Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Шилэн данс хөтлөх журам”-ыг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.
2. Журмын хэрэгжилтэнд хяналт тавьж, улирлын нэгдсэн тайланг дараа сарын 15-ны дотор танилцуулж ажиллахыг Хууль эрх, аудитын алба /Л.Батбаяр/-д даалгасугай.
3. Энэхүү журам батлагдсантай холбогдуулан Гүйцэтгэх захирлын 2019 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн “Шилэн данс хөтлөх тухай” А/42 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



М.ГАНБААТАР



ШИЛЭН ДАНС ХӨТЛӨХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэ журмын зорилго нь "Таван толгой түлш" ХХК /Цаашид Компани гэх/-ийн шилэн дансны цахим хуудсанд холбогдох алба, хэлтсүүд мэдээллээ хянаж баталгаажуулан байршуулах, мэдээллийн агуулга Шилэн дансны тухай хуулийн хугацаанд байршуулсан эсэхэд хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2. Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээлэл нь Төсвийн тухай хууль, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Компанийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд нийцсэн байна.

1.3 Компани нь Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3-т зааснаар тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.8-т заасан 5 төрлийн мэдээллийг байршуулна.

Хоёр. Байршуулах мэдээлэл

2.1. Компани нь өөрийн цахим хуудсанд шилэн дансны цэстэй байх бөгөөд шилэн дансны I) хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалт; II) бусад; гэсэн хоёр дэд цэсэд мэдээлэл байршуулна.

2.2. Энэ журмын 2.1-д заасан шилэн дансны дэд цэсэд дараах мэдээлэл багтана:

2.2.1. Хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалт:

2.2.1.1. худалдан авах ажиллагааны төлөвлөгөө;

2.2.1.2. хөрөнгийн болон урсгал зардалд тусгасан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэл;

2.2.1.3. концессын мэдээлэл;

2.2.1.4. худалдан авах ажиллагааны тайлан.

2.2.2. бусад:

2.2.2.1. нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдэл;

2.2.2.2. бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр;

2.2.2.3. Их хэмжээнд тооцогдохуйц хэлцэлд гаргасан баталгаа, батлан даалтын мэдээлэл.

Гурав. Байршуулах мэдээллийн хуулийн хугацаа, агуулга, хэлбэр

“Таван толгой түлш” ХХК-ны Гүйцэтгэх захирлын 2021 оны 02 дугаар сарын-ны өдрийн дугаар тушаалын хавсралт

ШИЛЭН ДАНС ХӨТЛӨХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэ журмын зорилго нь “Таван толгой түлш” ХХК /Цаашид Компани гэх/-ийн шилэн дансны цахим хуудсанд холбогдох алба, хэлтсүүд мэдээллээ хянаж баталгаажуулан байршуулах, мэдээллийн агуулга Шилэн дансны тухай хуулийн хугацаанд байршуулсан эсэхэд хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2. Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээлэл нь Төсвийн тухай хууль, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Компанийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд нийцсэн байна.

1.3 Компани нь Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3-т зааснаар тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.8-т заасан 5 төрлийн мэдээллийг байршуулна.

Хоёр. Байршуулах мэдээлэл

2.1. Компани нь өөрийн цахим хуудсанд шилэн дансны цэстэй байх бөгөөд шилэн дансны I) хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалт; II) бусад; гэсэн хоёр дэд цэсэд мэдээлэл байршуулна.

2.2. Энэ журмын 2.1-д заасан шилэн дансны дэд цэсэд дараах мэдээлэл багтана:

2.2.1. Хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалт:

2.2.1.1. худалдан авах ажиллагааны төлөвлөгөө;

2.2.1.2. хөрөнгийн болон урсгал зардалд тусгасан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэл;

2.2.1.3. концессын мэдээлэл;

2.2.1.4. худалдан авах ажиллагааны тайлан.

2.2.2. бусад:

2.2.2.1. нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдэл;

2.2.2.2. бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр;

2.2.2.3. Их хэмжээнд тооцогдохуйц хэлцэлд гаргасан баталгаа, батлан даалтын мэдээлэл.

Гурав. Байршуулах мэдээллийн хуулийн хугацаа, агуулга, хэлбэр

3.1. Компанийн шилэн дансны цахим хуудсанд байршуулах мэдээллийг дор дурдсаны дагуу тогтоосон хугацаанд нийтэд мэдээлнэ. Үүнд:

- 3.1.1. худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг энэ журмын 1 дүгээр хавсралтад заасан маягтын дагуу жил бүрийн 1 дүгээр сарын 10-ны дотор, цахимаар;
- 3.1.2. хөрөнгийн болон урсгал зардалд тусгасан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээллийг тендерийн хорооны дүгнэлт гарснаас хойш 7 хоногийн дотор энэ журмын 2 дугаар хавсралтад заасан маягтын дагуу цахимаар;
- 3.1.3. концессын мэдээллийг батлагдсанаас хойш 7 хоногийн дотор энэ журмын 3 дугаар хавсралтад заасан маягтын дагуу PDF форматаар;
- 3.1.4 худалдан авах ажиллагааны жилийн тайланг энэ журмын 4 дүгээр хавсралтад заасан маягтын дагуу дараа оны 1 дүгээр сарын 15-ны дотор тус цахимаар;
- 3.1.5. нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдлийг тухай бүр PDF форматаар;
- 3.1.6. бонд, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл болон төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд байгуулсан гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулсан, өр авлага үүсгэсэн аливаа шийдвэрийг гарсан өдрөөс хойш 7 хоногийн дотор энэ журмын 5 дугаар хавсралтад заасан маягтын дагуу PDF форматаар;
- 3.1.7. их хэмжээнд тооцогдохуйц хэлцэлд гаргасан баталгаа, батлан даалтын мэдээллийг батлагдсанаас хойш 7 хоногийн дотор энэ журмын 6 дугаар хавсралтад заасан маягтын дагуу PDF форматаар.

Дөрөв. Шилэн дансны цахим хуудсыг хөтлөх, ашиглах хэрэглэгчийн чиг үүрэг

4.1. Компанийн шилэн дансны цахим хуудсыг Хууль эрх зүй, аудитын алба хөтлөн явуулна.

4.2 Компанийн шилэн дансны цахим хуудас доор дурдсан үндсэн хэрэглэгчтэй байна:

- 4.2.1 Компанийн админ (Компанийн админ хэрэглэгчийн эрхийг Хууль эрх зүй, аудитын газрын дотоод хяналт шалгалтын мэргэжилтэн хариуцна);
- 4.2.2 мэдээлэл оруулах хэрэглэгч.

4.3. Компанийн админ хэрэглэгч дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

- 4.3.1. шилэн дансны цахим хуудасны мэдээлэл оруулах хэрэглэгчийн тохиргоог хийх;
- 4.3.2. мэдээлэл оруулах ажилтны хувийн мэдээллийг оруулах;
- 4.3.3. мэдээлэл оруулах хэрэглэгчийн байршуулсан мэдээллийг байнга хянах, үнэн зөв тавигдсан эсэхэд хяналт тавьж ажиллах;
- 4.3.4. тус журмын 3.1-д заасны дагуу тогтмол хугацаанд байршуулах мэдээллийг хугацаанаас нь өмнө мэдээлэл оруулах хэрэглэгчдэд сануулах, мэдэгдэл явуулах.

4.4. Мэдээлэл оруулах хэрэглэгч дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

- 4.4.1. Компанийн админ хэрэглэгчээс олгосон эрхийн дагуу байршуулах мэдээллийг холбогдох алба, хэлтсээс авч, Шилэн дансны тухай хууль, энэ журамд заасан хугацаанд оруулж баталгаажуулах;
- 4.4.2. бусад санхүүгийн систем, програмаас мэдээлэл татсан тохиолдолд тухайн мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулахаас өмнө үнэн зөв эсэхийг сайтар нягтлах;
- 4.4.3. мэдээлэл шилэн дансны цахим хуудсанд үнэн зөв тавигдсан эсэхийг шалгах.

4.5. Шилэн дансны цахим хуудсанд байршуулах мэдээллийг дараах алба, хэлтэс шилэн дансны мэдээлэл байршуулах мэргэжилтэнд гаргаж өгнө:

4.5.1 Бодлого, төсөл хөтөлбөрийн хэлтсийн мэргэжилтэн нь дараах мэдээллийг бэлтгэж, албаны даргаар баталгаажуулна:

4.5.1.1. концессын мэдээлэл;

4.5.1.2. бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр.

4.5.2. Санхүүгийн хэлтсийн нягтлан бодогч нь дараах мэдээллийг бэлтгэж ахлах нягтлан бодогчоор хянуулан, Санхүүгийн хэлтэсийн дарга бөгөөд Ерөнхий нягтлан бодогч баталгаажуулна:

4.5.2.1 их хэмжээнд тооцогдохуйц хэлцэлд гаргасан баталгаа, батлан даалтын мэдээлэл.

4.5.3. Худалдан авах ажиллагааны хэлтсийн мэргэжилтэн нь дараах мэдээллийг бэлтгэж, Худалдан авах ажиллагааны хэлтсийн даргаар хянуулан, Захиргаа удирдлагын албаны даргаар баталгаажуулна:

4.5.3.1. худалдан авах ажиллагааны төлөвлөгөө;

4.5.3.2. хөрөнгийн болон урсгал зардалд тусгасан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэл;

4.5.3.3. Худалдан авах ажиллагааны тайлан;

4.5.3.4. нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдэл.

Тав. Тайлагнах

5.1. Шилэн дансанд мэдээлэл байршуулсан хэрэглэгч буюу Хууль эрх зүй, аудитын албаны шилэн данс хариуцсан мэргэжилтэн нь тус албаны даргад улирал бүр дараа сарын 10-ны дотор тайлагнана.

5.2. Шилэн данс хариуцсан мэргэжилтэн нь улирлын нэгдсэн тайланг Хууль эрх зүй аудитын албаны даргаар хянуулан, Гүйцэтгэх захиралд дараа сарын 15-ны дотор хүргүүлнэ.

Зургаа.Бусад

6.1. Дараах тохиолдолд тус журамд өөрчлөлт оруулна:

6.1.1 Шилэн дансны тухай хууль болон Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журамд нэмэлт өөрчлөлт орсон;

6.1.2 Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлөөр бүтцэд нэмэлт, өөрчлөлт орсон.

6.2. Тус журмын нэмэлт өөрчлөлтийг Хууль эрх зүй, аудитын албаны шилэн данс хариуцсан мэргэжилтэн хариуцаж ажиллана.

6.3. Шилэн данс хариуцсан мэргэжилтэн нь мэдээлэл оруулах хэрэглэгчийн нэвтрэх нэр, нууц үгийг чандлан нууцлах, нууцлал алдагдах эрсдэл үүссэн тохиолдолд нууц үгийг заавал өөрчлөх үүрэгтэй.

6.4. Шилэн данс хариуцсан мэргэжилтнийг ажлын байр, бичгийн хэрэгсэл, шаардлагатай компьютер, принтер, бусад тоног төхөөрөмжөөр хангаж, ажиллах нөхцөлийг бүрдүүлнэ.

Долоо. Үүрэг, хариуцлага

7.1. Энэ журмыг зөрчсөн мэргэжилтэнд Компанийн Хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу хариуцлага ногдуулна.

---o0o---

ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

(Шилэн дансны тухай хуулийн 6.1.1 дэх заалтын хүрээнд)

Төрийн өмчийн аж ахуйн нэгжийн нэр:

№	Тухайн жилд худалдан авах бараа, ажил, үйлчилгээний нэр	Санхүүжилтийн эх үүсвэр	Төсөвт өртөг	Худалдан авах ажиллагаанд мөрдөх журам	Худалдан авах ажиллагаанд мөрдөх хугацаа			Хүчинтэй хугацаа	Урилга илгээгдсэн эсэх	Үр дүн оруулсан эсэх	Үр дүн илгээгдсэн эсэх
					Тендер зарлах огноо	Гэрээ байгуулах эрх олгох огноо	Гэрээ дуусгавар болгох, дүгнэх огноо				
1											
2											
Нийт дүн											

ХӨРӨНГИЙН БОЛОН УРСГАЛ ЗАРДАЛД ТУСГАСАН АРГА ХЭМЖЭЭНИЙ ТЕНДЕРИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

(Шилэн дансны тухай хуулийн 6.3.6, 6.4.3, 6.8.2 дахь заалтын хүрээнд)

Төрийн өмчийн аж ахуйн нэгж, байгууллагын нэр:

№	Тухайн жилд худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр	Батлагдсан төсөвт өртөг	Гэрээний дүн	Тендер шалгаруулалтыг явуулсан журам	Тендерт оролцохыг сонирхогчид тавьсан шалгуур үзүүлэлт	Тендерт шалгарсан оролцогчийн товч мэдээлэл	Тендерт шалгараагүй оролцогчийн товч мэдээлэл	Шалгараагүй талаарх үндэслэл, шалтгаан

КОНЦЕССЫН МЭДЭЭЛЭЛ

(Шилэн дансны тухай хуулийн 6.5.7 дахь заалтын хүрээнд)

/төгрөгөөр/

№	Концессын зүйлийн нэр	Концессын зүйлийн тодорхойлолт	Концессын төрөл	Гүйцэтгэх ажил, үзүүлэх үйлчилгээ	Төсвийн хөрөнгөөр санхүүгийн дэмжлэг үзүүлэх, баталгаа гаргах эсэх	Уралдаант шалгаруулалт явуулах, шууд гэрээ байгуулах эсэх	Концессын гэрээ	Концесс эзэмшигчийн нэр	Концесс эзэмшигчийн мэдээлэл
1. төслүүд								
1									
2									

Журмын хавсралт №4

ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

(Шилэн дансны тухай хуулийн 6.1.1 дэх заалтын хүрээнд)

Төрийн өмчийн аж ахуйн нэгжийн нэр:

Захиалагч байгууллагын нэр	Тухайн жилд худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, төрөл, тоо хэмжээ, хүчин чадал	Батлагдсан төсөвт өртөг (мян төг)	Гэрээний дүн (мян төг)	Гүйцэтгэгчийн нэр, гэрээний дугаар	Худалдан авах ажиллагаанд мөрдсөн журам	Сонин хэвлэл болон E- procurement сайтад тендерийн урилга нийтэлсэн огноо	Гэрээ байгуулах эрх олгосон огноо	Гэрээ байгуулсан огноо	Гэрээ дуусгаж дүгнэсэн огноо	Тайлбар тодруулга

БОНД, ӨРИЙН БИЧИГ, БАТАЛГАА, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ САНХҮҮГИЙН БУСАД ХЭРЭГСЭЛ,
ТӨР, ХУВИЙН ХЭВШЛИЙН ТҮНШЛЭЛИЙН ГЭРЭЭ, КОНЦЕСС, ТӨСӨВ, ӨМЧ, ХӨРӨНГӨ, МӨНГӨ ЗАРЦУУЛАХ,
ӨР, АВЛАГА ҮҮСГЭСЭН АЛИВАА ШИЙДВЭР

(Шилэн дансны тухай хуулийн 6.4.8, 6.8.1 дэх заалтын хүрээнд)

№	Шийдвэр гаргагч	Шийдвэрийн огноо	Шийдвэрийн дугаар	Төрөл (хөрөнгө зарцуулах, өр авлага үүсгэх ...)	Шийдвэрийн хуулбар
1					
2					

ИХ ХЭМЖЭЭНД ТООЦОГДОХУЙЦ ХЭЛЦЭЛД ГАРГАСАН БАТАЛГАА, БАТЛАН ДААЛТЫН МЭДЭЭЛЭЛ

(Шилэн дансны тухай хуулийн 6.8.3 дахь заалтын хүрээнд)

Төрийн өмчийн аж ахуйн нэгжийн нэр:

№	Хэлцлийн нэр /баталгаа, батлан даалт гаргуулсан этгээдийн нэр	Хэлцлийн дүн /баталгаа, батлан даалтын дүн	Хэлцлийн зориулалт	Хэлцлийн нөхцөл /баталгаа, батлан даалтын хугацаа, нөхцөл	Хэлцэл хийх/баталгаа, батлан заалт гаргахыг зөвшөөрсөн эрх бүхий байгууллагын шийдвэрийн	
					Огноо	Дугаар